БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүрээмарал сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/81/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор
2022 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com
Цахим хуудас: www.audit.mn

## Агуулга


1.Аудитын гэрчилгээ /эх хувь/ .......... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .......... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .......... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .......... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .......... 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .......... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .......... 11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан .......... 12
3. Аудитын тайлан .......... 13
3.1 Ерөнхий зүйл .......... 13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .......... 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......... 14
3.4 Материаллаг байдал .......... 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .......... 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .......... 16
3.8 Аудитын гол асуудал .......... 16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .......... 17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 17
4. Аудитын илрүүлэлт .......... 18
4.1.Төлбөрийн акт .......... 18
4.2. Албан шаардлага .......... 18
4.3. Залруулсан алдаа .......... 18
4.4. Зөвлөмж .......... 19
**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** .......... 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **51,282,228.00** | **56,808,378.00** |
| 33 | **АВЛАГА** | 10,620,000.00 | 500,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 500,000.00 |
| 335 | **Бусад авлага** | 10,620,000.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 10,620,000.00 | 00.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 40,662,228.00 | 56,308,378.00 |
| 351 | **Түүхий эд материал** | 00.00 | 2,878,000.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 2,878,000.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 40,662,228.00 | 53,430,378.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 50,000.00 | 323,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,219,150.00 | 1,485,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 39,393,078.00 | 51,621,078.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **365,274,931.30** | **353,786,012.62** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 365,274,931.30 | 353,786,012.62 |
| 392 | **Биет хөрөнгө** | 355,298,931.30 | 343,810,012.62 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 342,444,131.00 | 342,444,131.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -13,727,373.76 | -19,501,977.64 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 45,874,742.00 | 46,404,742.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -31,850,784.62 | -36,485,109.58 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,588,366.37 | 34,588,366.37 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -24,968,995.27 | -26,878,985.11 |
| 39217 | Ном | 2,938,845.58 | 3,238,845.58 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 9,976,000.00 | 9,976,000.00 |
| 39301 | Програм хангамж | 200,000.00 | 200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200,000.00 | -200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,976,000.00 | 9,976,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **416,557,159.30** | **410,594,390.62** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **194,349.00** | **00.00** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 194,349.00 | 00.00 |
| 413 | **Өглөг** | 194,349.00 | 00.00 |
| 4136 | **Бусад өглөг** | 194,349.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 194,349.00 | 00.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **416,362,810.30** | **410,594,390.62** |

| | | | |
|---|---|---|---|
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 416,362,810.30 | 410,594,390.62 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 102,844,487.00 | 102,844,487.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 102,844,487.00 | 102,844,487.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 30,889,036.26 | 25,120,616.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 30,889,036.26 | 30,889,036.26 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -5,768,419.68 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 282,629,287.04 | 282,629,287.04 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **416,557,159.30** | **410,594,390.62** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **285,219,170.00** | **287,946,585.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **7,448,500.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 7,448,500.00 | 00.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,448,500.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 7,448,500.00 | 00.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **277,770,670.00** | **287,946,585.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 228,833,700.00 | 225,920,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 228,833,700.00 | 225,920,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 25,535,070.00 | 38,345,388.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,535,070.00 | 38,345,388.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,401,900.00 | 23,680,597.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,401,900.00 | 23,680,597.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **269,285,108.60** | **293,715,004.68** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **269,285,108.60** | **293,715,004.68** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 239,341,664.29 | 225,101,785.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 162,162,891.69 | 152,880,007.00 |
| 210101 | Үндсэн цалин | 151,069,991.69 | 118,937,594.00 |
| 210102 | Нэмэгдэл | 4,944,000.00 | 20,420,627.00 |
| 210104 | Урамшуулал | 6,148,900.00 | 13,521,786.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,368,729.00 | 20,761,761.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,960,754.00 | 14,466,423.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,623,940.00 | 1,524,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,299,153.00 | 1,158,851.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 310,964.00 | 413,648.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,173,918.00 | 3,209,439.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,823,300.00 | 23,180,597.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,241,200.00 | 1,053,639.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,582,100.00 | 22,052,258.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 74,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,688,873.00 | 3,046,501.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 337,000.00 | 193,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,376,700.00 | 1,482,340.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 942,673.00 | 1,148,561.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 30,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 242,000.00 | 131,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 760,500.00 | 90,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 15,876,170.00 | 8,689,601.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 312,450.00 | 1,312,301.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,325,220.00 | 6,979,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 238,500.00 | 397,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,173,500.00 | 636,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,173,500.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 636,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 70,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 356,600.00 | 1,251,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 106,600.00 | 661,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,891,600.60 | 14,586,318.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 1,173,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,155,000.00 | 1,094,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,736,600.60 | 12,318,918.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,943,444.31 | 68,613,219.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 25,535,070.00 | 38,345,386.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,661,070.00 | 25,690,318.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,874,000.00 | 12,655,068.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,578,600.00 | 02.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,578,600.00 | 02.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,829,774.31 | 30,267,831.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,829,774.31 | 30,267,831.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **15,934,061.40** | **-5,768,419.68** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **15,934,061.40** | **-5,768,419.68** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **277,770,670.00** | **287,946,585.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **277,770,670.00** | **287,946,585.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 228,833,700.00 | 225,920,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 25,535,070.00 | 38,345,388.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,535,070.00 | 38,345,388.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,401,900.00 | 23,680,597.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,401,900.00 | 23,680,597.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **277,770,670.00** | **287,116,585.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **277,770,670.00** | **287,116,585.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **247,827,225.69** | **218,503,366.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 162,376,771.69 | 153,380,007.00 |
| 210101 | Үндсэн цалин | 118,501,578.27 | 116,019,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 20,599,699.42 | 20,667,091.00 |
| 210104 | Урамшуулал | 22,667,730.00 | 16,693,816.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 607,764.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,154,849.00 | 20,761,761.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,895,657.00 | 14,466,422.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,569,014.00 | 1,524,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,237,527.00 | 1,261,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 313,823.00 | 299,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,138,828.00 | 3,209,439.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,823,300.00 | 23,180,597.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,241,200.00 | 1,053,639.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,582,100.00 | 22,052,258.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 74,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,426,985.00 | 8,548,001.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 29,000.00 | 179,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,376,700.00 | 1,482,340.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 942,673.00 | 1,148,561.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 30,000.00 | 14,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 242,000.00 | 131,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 806,612.00 | 5,591,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 28,299,220.00 | 7,996,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,531,600.00 | 618,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,325,220.00 | 6,979,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,442,400.00 | 397,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,713,500.00 | 636,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,713,500.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 636,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 70,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 356,600.00 | 1,251,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 106,600.00 | 661,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,676,000.00 | **2,679,800.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 1,970,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,676,000.00 | 709,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **29,943,444.31** | **68,613,219.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 25,535,070.00 | 38,345,386.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,661,070.00 | 25,690,318.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,874,000.00 | 12,655,068.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,578,600.00 | 02.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,578,600.00 | 02.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 2,829,774.31 | 30,267,831.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,829,774.31 | 30,267,831.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **830,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **830,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **830,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 830,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 830,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-830,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 92,416,831.00 | 155,322,218.50 | -35,997,741.84 | 211,741,307.66 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **92,416,831.00** | **155,322,218.50** | **-35,997,741.84** | 211,741,307.66 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -11,923,490.16 | -11,923,490.16 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **102,844,487.00** | **282,629,287.04** | **30,889,036.26** | 416,362,810.30 |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **102,844,487.00** | **282,629,287.04** | **30,889,036.26** | 416,362,810.30 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **102,844,487.00** | **282,629,287.04** | **30,889,036.26** | 416,362,810.30 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -5,768,419.68 | -5,768,419.68 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **102,844,487.00** | **282,629,287.04** | **25,120,616.58** | 410,594,390.62 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 250,046,600.00 | 219,333,366.00 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 250,046,600.00 | 219,333,366.00 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 249,957,900.00 | 219,333,366.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 164,446,800.00 | 153,380,007.00 |
| 210101 | Үндсэн цалин | 119,019,100.00 | 116,019,100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 19,621,100.00 | 20,667,091.00 |
| 210104 | Урамшуулал | 25,806,600.00 | 16,693,816.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22,295,300.00 | 20,761,761.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,837,400.00 | 14,466,422.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,614,500.00 | 1,524,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,291,700.00 | 1,261,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 322,800.00 | 299,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,228,900.00 | 3,209,439.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,626,000.00 | 23,180,597.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,871,200.00 | 1,053,639.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,454,800.00 | 22,052,258.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 74,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,227,600.00 | 8,848,001.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 179,800.00 | 179,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 | 1,482,340.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,371,900.00 | 1,148,561.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 344,400.00 | 314,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 131,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,591,500.00 | 5,591,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25,182,500.00 | 7,996,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 641,400.00 | 618,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,143,300.00 | 6,979,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 397,800.00 | 397,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 636,000.00 | 636,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 636,000.00 | 636,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 82,800.00 | 70,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 82,800.00 | 70,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,251,100.00 | 1,251,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 661,100.00 | 661,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 350,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3209800.00 | 3209800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 709,800.00 | 709,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 88700.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 88,700.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 88,700.00 | 00.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 250,046,600.00 | 219,333,366.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 225,920,600.00 | 195,652,769.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 225,920,600.00 | 195,652,769.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 24,126,000.00 | 23,680,597.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 24,126,000.00 | 23,680,597.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 16.00 | 16.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 105.00 | 105.00 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 105.00 | 105.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **16.00** | **16.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 11.00 | 11.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 05.00 | 05.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **25,535,070.00** | **38,345,386.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **25,535,070.00** | **38,345,386.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 25,535,070.00 | 38,345,386.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 25,535,070.00 | 38,345,386.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,661,070.00 | 25,690,318.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,874,000.00 | 12,655,068.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 25,535,070.00 | 38345388.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 25,535,070.00 | 38,345,388.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,535,070.00 | 38,345,388.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хүрээмарал сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүрээмарал сумын Цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Цэцэрлэгийн эрхлэгч Я.Оюунчимэг нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Д.Оюунгэрэл нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүрээмарал сумын Цэцэрлэг нь багш бүр хүүхдийн өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжиж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, сурах үйлийн таатай орчныг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь салбарын хэмжээнд мөрдөх холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын алба байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Хүрээмарал сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүрээмарал сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 269,179.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,037.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,028.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3,294.4 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүрээмарал сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 410,594.4 мянган төгрөг болж өмнөх оноос 5,962.8 мянган

төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материалын данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 51,282.2 | 56,808.4 | 5,526.1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 10,620.0 | 500.0 | (10,120.0) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 40,662.2 | 56,308.4 | 15,646.2 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 365,274.9 | 353,786.0 | (11,488.9) |
| Үндсэн хөрөнгө | 436,022.1 | 436,852.1 | 830.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (70,747.2) | (83,066.1) | (12,318.9) |
| **Нийт хөрөнгө** | 416,557.2 | 410,594.4 | (5,962.8) |
| Өр төлбөр | 194.3 | - | (194.3) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 416,362.8 | 410,594.4 | (5,768.4) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 416,557.2 | 410,594.4 | (5,962.8) |

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлангаас авав.

Бараа материалын дансны үлдэгдэл 56,308.4 мянган төгрөг болж 15,646.2 мянган төгрөгөөр өссөн бусад хангамжийн материалын үлдэгдэл 12,228.0, эм боох материал 2,828.0 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Авлага данс оны эхэнд 10,620.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсныг бүрэн барагдуулсан ба шинээр цалингийн урьдчилгаа суутган тооцоогүй авлага үүссэнд төлбөрийн акт тогтоосон.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 436,852.1 мянган төгрөг болж 830.0 мянган төгрөгөөр өссөн нь нь төсвийн хөрөнгөөр ном, бусад хөрөнгө худалдан авсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 410,594.4 мянган төгрөг болж өмнөх оноос 5,768.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 38,345.4 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх зарлагыг 234,227.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 29,517.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 263,744.7 мянган төгрөгөөр батлагдсан ба аймгийн Засаг даргын 2021.05.06-

ний А/289 тоот, 2021.12.06-ны А/742 тоот захирамжуудаар төсвийн зохицуулалт хийгдэж 250,046.6 мянган төгрөгөөр тайлант жилийн төсөв батлагдсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 250,046.6 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 225,920.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 24,126.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 225,920.6 мянга, орон нутгийн төсвөөс 23,680.6 мянга нийт 249,601.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 219,333.4 мянган төгрөгийг зарцуулж 30,267.8 мянган төгрөг буюу 12,1 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 445.4 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 219,333.4 мянган төгрөг буюу 87,7 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 12,589.4 мянган төгрөг, нормативд зардлыг 17,186.2 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 38,345.4 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Ч.Чимгээ аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт 32 ажил төлөвлөснөөс биелэлт 96 хувьтай хэрэгжсэн гэж тайлагнасан.

## 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 298,490.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 14,361.5 мянган төгрөгөөр буюу 4,9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, НДШ-ийн зардал, хангамж, бараа материалын зардал өсөж, нормативд зардал буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллээс бүтэн жилээр мэдээлэх дараа жилийн төсвийн төсөл, байгууллагын батлагдсан төсвийн төслийн нийт 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### 3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 24,989.9 мянган төгрөг ба батлагдсан төсвийн 20 хувь нь 4,998.0 мянган төгрөг байна. Төсвийн зохицуулалтаар 1,363.9 мянган төгрөгөөр хассан, гүйцэтгэлээр 445.4 мянган төгрөгийн хэмнэлт, нийт 1,809.3 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байгаа нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### 3.9.3. Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 44,599.5 мянган төгрөгийн хүүхдийн хоол худалдан авах ажиллагааг сумын ЗДТГ зохион байгуулсан ба "Баянбат мандал" ХХК-тай гэрээ байгуулсан байна. .

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан, нийт 1,520.0 мянган төгрөгийн зөрчил илэрч санхүүгийн тайланд залруулга хийгдсэн ба хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах 1 заалт бүхий зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021.06.10-нд гарган Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,462.5 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрч, 857,8 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 881.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага өгч, 723.5 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах 1 заалт бүхий зөвлөмж өгөв.

### 4.1.Төлбөрийн акт

**4.1.1.** Ажилтнуудад 2021 оны 8 дугаар сард олгосон урьдчилгаа цалингаас 500.0 мянган төгрөгийг суутгаагүй, авлагаар тусгаагүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ,14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Ангилал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Холбогдох ажилтнаар 500.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

**4.1.2.** Нягтлан бодогчийн 1,3-р улирлын үр дүнгийн урамшуулал цалинг үндсэн орон тооны ажилтны цалингаас бодож 357.8 мянган төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан" Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"- 4.2. Энэ журмын 4.1-д заасан албан хаагч гэдэгт сургалтын байгууллагын төсвөөс цалинждаг орон тооны ажилтан хамаарна. 4.5.Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно.гэснийг зөрчсөн нь санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Холбогдох ажилтнаар 357.8 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 4.2. Албан шаардлага

**4.2.1.** 2021 оны 7 дугаар сард Нийгмийн даатгалын хэлтэст 10 ажилтны цалингийн санг 881.2 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 881.2 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага бичсэн.

### 4.3. Залруулсан алдаа

**4.3.1** Горим сорил гүйцэтгэх явцад дараах 723.5 мянган төгрөгийн алдаа илрэв. Үүнд:

- Аж ахуйн материалын зарлагыг нягтлан бодох бүртгэлд нярвын тайлангаас 130.0 мянган төгрөгөөр дутуу зарлагадсан

-Тооллогоорх аж ахуйн материалын үлдэгдэл санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 462.0 мянган төгрөгөөр зөрүүтэй нь нярав 462.0 мянган төгрөгийн гэрлийг орлого авч, шаардахаар зарлагадсан байхад нягтлан бодох бүртгэлд зарлага гаргаагүй

- Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 131.5 мянган төгрөгийн шатахууныг нярав орлого, авч зарлагадсан байхад нягтлан бодох бүртгэлд шууд зардлаар тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" , " Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь**: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." гэснийг үндэслэн 261.5 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд, 462.0 мянган төгрөгийн алдааг нярвын материалын тайланг засуулав.

**4.4. Зөвлөмж**

**4.4.1**. Тайлант онд тогтмол зардалд анхны батлагдсан төлөвлөгөөгөөр 24,989.9 мянган төгрөг батлагдсан ба батлагдсан төсвийн 20 хувь нь 4,998.0 мянган төгрөг байна. Төсвийн гүйцэтгэлээр 1,809.3 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын "1.8. байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг байгууллагын удирдлага хэрэгжүүлж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хүрээмарал сумын Цэцэрлэг | 5 | 2,462.5 | 1 | 723.5 | 2 | 857.8 | 1 | 881.2 | 1 | |

oOo